БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр Дугаар А/60 Булган

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Засгийн газрын 2022 оны 56 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Улсын аварга малчин өрх”, “Улсын аварга саальчин”, “Улсын аварга тариаланч”, “Улсын аварга тариаланч хамт олон”-оор шалгарсан аймгийн малчин, саальчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлсүгэй. Үүнд:

“Улсын аварга малчин өрх”-өөр:

- Гурванбулаг сумын Тогоо багийн малчин Дашдэндэвийн Цэлхаасүрэн;
- Орхон сумын Халиун багийн малчин Ёндонжамцын Мандах;
- Хутаг-Өндөр сумын Хантай багийн малчин Гэндэнжамцын Баасанжаргал;
- Бүрэгхангай сумын Дэрст багийн малчин Нувааны Эрдэнэбат;
- Дашинчилэн сумын 2 дугаар багийн малчин Содномын Бүрэн;

“Улсын аварга саальчин”-аар:

- Бугат сумын Ханжаргалант багийн саальчин Ганбаатарын Бямбасүрэн;

“Улсын аварга тариаланч”-аар:

- Сэлэнгэ сумын “Ингэт толгой” ХК-ийн механикжуулагч Могойторын Сүхбаатар;
- Хутаг-Өндөр сумын “Булган буудайн түрүү” ХХК-ийн механикжуулагч Алтангэрэлийн Батсайхан;

“Улсын аварга тариаланч хамт олон”-оор:

- Баян-Агт сумын “Актив агро” ХХК;
- Рашаант сумын “Ти эн эс эн ти” ХХК;

2. Улсын аварга малчин, саальчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

20220071

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3 000 000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 07 -ний өдрийн А/60
тоот захирамжийн хавсралт

ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Талархал	10	40 000	400 000
2	Гарын бэлэг	10	260 000	2 600 000
	Нийт			**3 000 000**

. . . o O o . . .